

Үрилга

МЭДЭЭЛЭЛТЭЙ, ЭРХ МЭДЭЛТЭЙ ИРГЭД

АНУ-ын Коннектикут мужийн Хамден хотын туршлага

Мэдээлэл авах эрх, эрх чөлөө, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцооны талаар бид нэлээд хэдэн жил ярьсаар ирсэн ч бодитой үр дүнд хүрсэн нь цөөн. Энэ чиглэлээр яагаад бодит өөрчлөлт гарагүй байна вэ? Цаашид бид хэрхэх ёстой вэ? Эдгээр асуултад хариулт эрэн АНУ-ын Коннектикут мужийн Хамден хотын туршлагыг судлаад ирсэн

Ц. Оюунгэрэл (Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн), **Н. Энхтувшин** (Хан-Уул дүүргийн

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга) нартай Таныг уулзахыг урьж байна.



Энэтхэг Улс, Банта хот

Чанчала Дэви доод гаралтай, хар бор ажил олдвол хийж амьдрал залгуулдаг, гурван хүүхдтэй өрх толгойлсон эмэгтэй. Олон жилийн өмнө шавар, сүрлээр барьж босгосон тохижуутай оромжныхоо оронд авсаархан тохиолг тоосгон байшинтай болохыг мөрөөднө. Тосгоноос түүнтэй адил ядуу өрхүүдэд орон байртай болоход нь 700 долларын буцалтгүй тусламж олгож байгааг сонсоод тэр даруй өргөдлөө өгсөн ч сураг сонсогүй байсаар 4 жилийн нүүр узжээ. Харин энэ хугацаанд чинээлэг хөрш нь буцалтгүй тусламжид хамрагдан сайхан байшин бариад амжсан аж. Саяхан Дэви “Мэдээлэл авах эрх чөлөөний тухай” хууль батлагдсаныг олж мэдээд дээрх тусламжид өдий хүртэл ямар хүмүүс хамрагдаад байгаа, яагаад түүнд өгөх боломжгүйг тайлбарлахыг шаардсан хүсэлтээ нутгийн захиргаандaa тавьжээ. Үүнээс хойш хэдхэн өдрийн дотор тосгоны захиргаанаас Девитэй холбогдож өөрт нь буцалтгүй тусламж олгох болсныг дуулгасан байна.



Монгол Улс, Улаанбаатар хот

Өлзий гуай хот бараадаад хэдэн жилийн нүүр үзэж буй тэтгэврийн хөгшин. Чингэлтэй дүүргийн 13-р хороонд оршин сууна. Хүйтний улирал айсүй тул 4 ханатай гэрээ өвөлдөө дулаан байлах түлээ түлш, дулаалга базаах гээд сүүлийн үед нойр хулжин санаа зөвнхөн болжээ. Уг нь энэ жил Улаанбаатарын хотын утааг багасгах хөтөлбөрийн хүрээнд өөр шиг нь орлого багатай тэтгэврийн хөгшдөө дулаалга хямд үнээр олгох гэж байгаа тухай сураг сонсоод гурван сарын өмнө хороондоо өргөдөл өгсөн ч сураг ажиггүй байсаар өвөлтэй золгожээ.

Үзүүлэлт

2010 оны 11 дүгээр сарын 5-ны
15.30-17 цагт Нээлттэй Нийгэм Форумын Хурлын танхимд болно.
Оролцох хүмүүс **313207** утсаар холбогдож бүртгүүлнэ үү.